# ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 09 сарын 25 өдөр Дугаар А/271 Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах
тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.3 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 168 дугаар тогтоолоор батлагдсан "Агаарын тээврийг хялбаршуулах журам"-ын 2.1.2 дахь заалт Иргэний нисэхийн дүрэм-172-ын 172.85.(а) дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам"-ыг хавсралтаар шинэчлэн батлагдсугай.

2.Энэ журам батлагдсантай холбогдуулан хэрэгжилтийг зохион байгуулах, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Төлөвлөлт, зохицуулалтын газар (П.Ганболд)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит, аюулгүй байдлын удирдлагын газар (С.Мөнхнасан)-т үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2026 оны А/76 дугаартай "Журам батлах тухай" тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Г.БАТБАЯР

1712502 0916

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2026 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн
А/171 дугаар тушаалын хавсралт

# НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙГ ТӨЛӨВЛӨХ, ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ

Хувилбар 14

2026 он

# ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

| Хувилбар | Өдөр | Баталгаажуулсан | Өөрчлөлтийн утга |
|---|---|---|---|
| 1 | 1999 | НХҮҮТ-ийн Мэргэжлийн хэлтэс | Журмыг гаргав. |
| 2 | 2005.12.14 | 613 дугаар тушаал | Тогтоогдсон агаарын зайд нислэгийн урсгал төлөвлөлт, гүйцэтгэл, мэдээллийг зохицуулах журам |
| 3 | 2007.06.29 | 476 дугаар тушаал | Нислэгийн хөдөлгөөний урсгалын төлөвлөлт, зохицуулалтын журам |
| 4 | 2008.09.22 | 627 дугаар тушаал | Монгол Улсын агаарын зайд нислэгийн зөвшөөрөл олгох, нислэгийн хөдөлгөөний урсгалыг төлөвлөх, түүний гүйцэтгэлийг бүртгэх, мэдээллийг дамжуулах журам |
| 5 | 2010.09.24 | А/385 дугаар тушаал | Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам |
| 6 | 2011.09.21 | А342 дугаар тушаал | Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам |
| 7 | 2014.06.23 | А294 дүгээр тушаал | Агаарын хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам |
| 8 | 2015.06.02 | А275 дугаар тушаал | Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам |
| 9 | 2016.01.15 | А/30 дугаар тушаал | Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам |
| 10 | 2018.07.20 | А/427 дугаар тушаал | “Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам” Монгол Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын 1.2.9 дэх заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор “Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам”-ын алба, хэлтэс, салбарын нэр томьёоны өөрчлөлт |
| 10 | 2018.10.15 | А/654 дүгээр тушаал | “Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журмын 4 дэх хэсгийн 4.10 дахь заалт төлөвлөлтийн үйл ажиллагаанд тавигдах үндсэн шаардлага; 7 дугаар зүйлийн 7.1, 7.1.1, 7.2.2, 7,1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.6 заалт олон улсын хуваарьт бус нислэгийн хүсэлтэд тус тус өөрчлөлт оров. |
| 11 | 2021.08.30 | А/106 дугаар тушаал | Журамд бүхэлд нь өөрчлөлт оруулж, шинэчлэн найруулсан. |
| 12 | 2022.05.05 | А/100 дугаар тушаал | Журамд бүхэлд нь өөрчлөлт оруулж, шинэчлэн найруулсан. |
| 12 | 2022.07.05 | А/190 дүгээр тушаал | Журамд нэмэлт өөрчлөлт оруулав. Үүнд: 3.1.6, 3.1.7, 5.3.2 заалтуудыг нэмэлтээр, 3.1.12, 5.1.1, 5.1.2, 5.2.1, 9.1 заалтуудад өөрчлөлт оруулав. |
| 12 | 2023.08.18 | А/252 дугаар тушаал | Журамд нэмэлт, өөрчлөлт оруулав. Үүнд: 3.1.4, 4.1.4, 4.3.2, 8.1.2, 8.2.1, 9.1 дэх заалт, Хавсралт 1-т тус тус өөрчлөлт оруулав. |
| 13 | 2026.03.10 | А/76 дугаар тушаал | Журамд бүхэлд нь өөрчлөлт оруулж, шинэчлэн найруулсан. |
| 14 | 2026.09..... | ..... дугаар тушаал | Журамд өөрчлөлт оруулж, шинэчлэн найруулсан. |

## ГАРЧИГ

НЭГ. Нийтлэг үндэслэл ..... 3
ХОЁР. Нэр томьёо, тодорхойлолт ..... 3
ГУРАВ. Нислэгийн зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага ..... 5
ДӨРӨВ. Нислэгийн хүсэлт гаргахад тавигдах шаардлага ..... 6
ТАВ. Нислэгийн өөрчлөлтөд тавигдах шаардлага ..... 7
ЗУРГАА. Нислэгийн зөвшөөрөл ..... 8~~7~~
ДОЛОО. Нислэгийн зөвшөөрлийн хүчинтэй хугацаа болон цуцлалт ..... 8
НАЙМ. Баримт бичигт тавигдах шаардлага ..... 9
ЕС. Ерөнхий зориулалтын нисэх ..... 11
АРАВ. Харилцагч байгууллагын хамтын ажиллагаа ..... 11
АРВАН НЭГ. Нислэгийн төлөвлөлтийн мэдээний хадгалалт ..... 12
АРВАН ХОЁР. Хавсралт ..... 12
ХАВСРАЛТ 1 ..... 13
ХАВСРАЛТ 2 ..... 14
ХАВСРАЛТ 3. ..... 15
ХАВСРАЛТ 4. ..... 16
ХАВСРАЛТ 5. ..... 17

# НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙГ ТӨЛӨВЛӨХ, ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ

## НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1 Энэ журмын зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэр, агаарын зайд үйлдэх нислэгийг төлөвлөх, нислэгийн хөдөлгөөний урсгалыг аюулгүй, үр ашигтай, шуурхай зохицуулан, нислэг үйлдэх зөвшөөрөл олгоход оршино.

1.2 Энэ журмаар Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид "ИНЕГ" гэх), "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК, түүний харьяа Нислэгийн урсгал төлөвлөлтийн байгууллага (цаашид "НУТБ" гэх) болон нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн үйл ажиллагаанд оролцогч талуудын хамтын ажиллагаа, үүрэг оролцоог тодорхойлж, зохицуулна.

1.3 Монгол Улсын агаарын зайд үйлдэх хуваарьт болон хуваарьт бус нислэг ИНЕГ-аас олгосон нислэгийн зөвшөөрлийн дагуу үйлдэгдэнэ.

1.4 НУТБ нь нислэгийн хүсэлт гаргагчаас ирүүлсэн нислэгийн хүсэлт, түүнд холбогдох баримт бичгийг хүлээн авч, ИНЕГ-ын олгосон нислэгийн зөвшөөрлийн дагуу нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлнэ.

1.5 Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгохдоо Монгол Улсын агаарын зайд үйлдэх нислэгийн хөдөлгөөн, агаарын зайн болон нисэх буудлын багтаамжийг харгалзана.

1.6 Нислэгийн хөдөлгөөнийг дараах төрлөөр төлөвлөнө. Үүнд:

1.6.1 Урт хугацааны;
1.6.2 Урьдчилсан;
1.6.3 Шуурхай;
1.6.4 Үйл ажиллагааны дараах;

## ХОЁР. Нэр томьёо, тодорхойлолт

2.1 Журамд хэрэглэсэн нэр томьёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

2.1.1 **"Нислэгийн урсгал төлөвлөлтийн байгууллага"** гэж Монгол Улсын агаарын зайд үйлдэгдэх иргэний агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөний урсгалыг төлөвлөн зохицуулах, нислэгийн зөвшөөрлийг дамжуулах эрх бүхий байгууллагыг;

2.1.2 **"Албан захиалгат нислэг"** гэж дипломат шугамаар ирүүлсэн онцгой үүргийн нислэгээс бусад Гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжиж ирсэн нислэгийг;

2.1.2.1 **"Онцгой үүргийн нислэг"** гэж Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, гадаад улсын өндөр хэмжээний зочдод үйлчлэх нислэгийг;

2.1.2.2 **"Тусгай үүргийн нислэг"** гэж тайван цагийн батлан хамгаалах нислэг, хил хамгаалалт, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үүрэг гүйцэтгэхтэй

холбогдолтой нислэг болон гамшиг, аюулт үзэгдэлтэй тэмцэх, эмнэлгийн яаралтай, түргэн тусламжийн зорилгоор үйлдэж буй бүх төрлийн нислэгийг;

2.1.3 **"Нислэгийн зөвшөөрөл"** гэж Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх агаарын хөлөгт ИНЕГ-аас олгож буй дамжин өнгөрөх, хөөрөлт буулт үйлдэх эсхүл техникийн зогсолт үйлдэх эрхийг хэлэх ба дараах төрлүүдтэй байна. Үүнд:

2.1.3.1 **"Дамжин өнгөрөх нислэгийн зөвшөөрөл"** гэж Монгол Улсын агаарын зайд нэвтрэх, дамжин өнгөрөх зөвшөөрлийн мэдэгдлийг;

2.1.3.2 "**Хөөрөлт, буултын нислэгийн зөвшөөрөл"** гэж зөвшөөрөгдсөн нисэх буудалд хөөрөлт, буулт үйлдэх эсхүл техникийн зогсолт үйлдэх агаарын хөлгийн нислэгт Монгол Улсын агаарын зайг ашиглах зөвшөөрлийн мэдэгдлийг;

2.1.3.3 "**Албан захиалгат нислэгийн зөвшөөрөл"** гэж засгийн газрын болон цэрэг, хүмүүнлэгийн зориулалтаар үйлдэгдэх агаарын хөлгийн нислэгт Гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан олгох Монгол Улсын агаарын зайг ашиглах зөвшөөрлийн мэдэгдлийг;

2.1.4 **"Нислэгийн хүсэлт /FLT REQ/"** гэж нислэгийн хүсэлт гаргагчаас ирүүлсэн нислэгт шаардагдах бүх мэдээллийг агуулсан баримтыг;

2.1.5 **"Нислэгийн хүсэлт гаргагч"** гэж Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэхээр нислэгийн зөвшөөрөл хүсэгч хувь хүн, хуулийн этгээдийг;

2.1.6 **"Нэмэгдэл нислэг"** гэж хуваарьт нислэгийн цагийн хуваарьт тодорхой хугацаанд нэмэгдэх нислэгийг;

2.1.7 **"Олон улсын нислэг"** гэж хоёр буюу түүнээс дээш улсын агаарын зайд үйлдэх нислэгийг;

2.1.8 **"Орон нутгийн нислэг"** гэж Монгол Улсын агаарын зайд үйлдэх нислэгийг;

2.1.9 **"Өөрчлөлт орсон нислэг"** гэж тухайн өдөр төлөвлөгдсөн нислэгт урьдчилсан болон шуурхай төлөвлөлтөөр өөрчлөлт орохыг;

2.1.10 **"Улирал"** гэж зуны улирал: гуравдугаар сарын сүүлийн Ням гарагт эхлэхийг, өвлийн улирал: аравдугаар сарын сүүлийн Ням гарагт эхлэхийг;

2.1.11 **"Улсын агаарын хөлөг"** гэж цэрэг, цагдаа, хил хамгаалах, гаалийн болон төрийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын агаарын хөлгийг;

2.1.12 **"Улсын нисэх"** гэж улсын агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэхтэй холбогдсон цогцолбор ойлголтыг;

2.1.13 **"Урт хугацааны төлөвлөлт"** гэж өвөл, зуны улирлын хугацаанд тогтмол давтамжтай үйлдэгдэх нислэгийн төлөвлөлтийг;

2.1.14 **"Урьдчилсан төлөвлөлт"** гэж нислэгийн үйл ажиллагаа эхлэхээс нэг хоногийн өмнөх өдрөөс 7 хоног хүртэлх хугацааны төлөвлөлтийг;

2.1.15 **"Урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээ"** гэж ИНЕГ-аас зөвшөөрөл олгогдож нислэгийн төлөвлөлтөд тусгагдаж баталгаажсан, тухайн өдөр үйлдэгдэх нислэгийн цагийн хуваарийн мэдээллийг нэгтгэсэн баримт бичгийг;

2.1.16 **"Үйл ажиллагааны дараах төлөвлөлт"** гэж гүйцэтгэсэн нислэгийн мэдээлэлд тулгуурлан дүн шинжилгээ хийж, дахин төлөвлөлт хийхийг;

2.1.17 **"Хилийн агаарын бүс"** гэж улсын хилийн шугамаас дотогш 30 км–ийн өргөнтэй нутаг дэвсгэр дээрх агаарын зайг;

2.1.18 **"Хойшилсон нислэг"** гэж тухайн өдөр төлөвлөгдсөн боловч, тодорхой шалтгааны улмаас тодорхой хугацаагаар хойшлогдсон нислэгийг;

2.1.19 **"Хуваарьт бус нислэг"** гэж хуваарьт нислэгээс бусад нислэгийг;

2.1.20 **“Хуваарьт нислэг”** гэж олон нийтэд нээлттэй зарласан хуваарийн дагуу тогтмол давтамжтайгаар гүйцэтгэх нислэгийг;

2.1.21 **“Цуцалсан нислэг”** гэж тухайн өдөр төлөвлөгдсөн боловч тодорхой шалтгааны улмаас үйлдэгдэхгүй болсон нислэгийг;

2.1.22 “**Шуурхай төлөвлөлт**” гэж тухайн өдөр төлөвлөгдсөн нислэгийн өөрчлөлтийг хийж, нислэгийг шинээр төлөвлөхийг;

2.2 Бусад нэр томьёог Иргэний нисэхийн дүрмийн нэр томьёоны тайлбар болон MNS 6409:2024 Иргэний нисэх. Ерөнхий нэр томьёо тодорхойлолтод заасны дагуу ойлгоно.

**ГУРАВ. Нислэгийн зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага**

3.1 Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх зөвшөөрөл олгохдоо дараах шаардлагыг тавина. Үүнд:

3.1.1 Гадаад улсын онцгой үүрэг, тусгай үүрэг болон албан захиалгат нислэгийн хүсэлтийг Гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан хүлээн авна.

3.1.2 Дотоодын онцгой үүргийн нислэгийн мэдээллийг төрийн тусгай хамгаалалтын байгууллагаар дамжуулан хүлээн авна.

3.1.3 Улсын агаарын хөлгийн нислэгийг Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль, Улсын нисэхийн тухай хууль, Улсын агаарын хөлгийн онцгой болон тусгай үүргийн нислэгийн хөдөлгөөнийг зохицуулах хамтарсан журмын дагуу зохицуулна.

3.1.4 Монгол Улсын хил болон хилийн агаарын бүс орчимд нислэг үйлдэх тохиолдолд Монгол Улсын Хилийн тухай хууль, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль, Монгол–Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол-БНХАУ-ын Засгийн газар хоорондын гэрээ, Орос–Монголын хилийн дэглэмийн тухай гэрээ, холбогдох бусад дүрэм, журам болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.

3.1.5 Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан Дархан цаазат болон Байгалийн цогцолбор газарт нислэг үйлдэх тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна. Зөвшөөрөлтэй холбоотой хариуцлагыг нислэгийн хүсэлт гаргагч бүрэн хариуцна.

3.1.6 Нислэгийн хүсэлт гаргагч (гадаад улсын болон гадаад улсад бүртгэлтэй агаарын хөлөг)-аас ирүүлсэн орон нутгийн хуваарьт бус нислэг үйлдэх хүсэлтийг тухайн улстай байгуулсан Засгийн газар хоорондын агаарын харилцааны хэлэлцээр болон бусад холбогдох бичиг баримтыг үндэслэн нислэгийн зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

3.1.7 Нислэгийн хүсэлт гаргагчаас ирүүлсэн олон улсын хуваарьт бус хөөрөлт, буултын нислэгийн хүсэлт, түүнд холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, агаарын зайн болон нисэх буудлын багтаамж, газрын үйлчилгээний мэдээлэл зэрэг бусад хүчин зүйлүүдийг харгалзан нислэгийн зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

3.1.8 Зөвшөөрөл олгох тохиолдолд агаарын зайн болон нисэх буудлын багтаамж, газрын үйлчилгээний мэдээлэл зэрэг бусад хүчин зүйлүүдийг харгалзан нислэгийн өдөр, цагийг өөрчлүүлж болно.

3.1.9 Нислэгийн үйл ажиллагааг холбогдох иргэний нисэхийн дүрмээр зохицуулна.

3.1.10 Нислэгийн хүсэлт гаргагч (дотоод)-аас ирүүлсэн хуваарьт болон хуваарьт бус нислэгийн хүсэлтэд зөвшөөрөл олгохдоо энэхүү журмын 10.2.1 дэх заалтыг үндэслэн нислэгийн төлөвлөлт зөвшөөрлийн үйл ажиллагааг зохион байгуулна.

3.1.11 Давагдашгүй хүчин зүйлс (гамшгаас хамгаалах бэлэн байдал зарласан, агаарын хил хаагдсан, байгалийн гамшиг ...гэх мэт) үүссэн тохиолдолд нислэгийн зөвшөөрлийг олгохдоо агаарын навигацийн хураамжийн төлбөрийг нэмэгдэлгүйгээр тооцож болно.

3.1.12 Журмын 4.3.1, 4.3.2-т заасан хугацаанаас богино хугацаанд хуваарьт бус нислэгийн зөвшөөрөл авахаар хүсэлт ирүүлсэн тохиолдолд агаарын навигацийн хураамжийн төлбөрийг зохих нэмэгдэлтэйгээр тооцож, нислэгийн зөвшөөрлийг олгоно.

3.1.13 Нислэгийн төлөвлөгөө, хүсэлт болон түүнд холбогдох баримт бичгийн мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр байдлыг нислэгийн хүсэлт гаргагч бүрэн хариуцна.

3.1.14 Нислэг үйлдэхэд шаардагдах баримт бичигт өөрчлөлт орсон талаарх мэдээллийг нислэгийн хүсэлт гаргагч тогтмол шинэчлэн ирүүлнэ.

3.1.15 Баримт бичгийн бүрдэл дутуу, зөрчилтэй, хугацаа дууссан, хүчингүй болсон, агаарын зайн болон нисэх буудлын багтаамж, нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсээс шалтгаалан нислэгийн зөвшөөрөл олгохоос татгалзаж болно.

3.1.16 Нислэгийн хүсэлт гаргагчид нислэгийн зөвшөөрөл олгох баримт бичгийн шаардлага хангаагүйгээс үүдэн нислэгийн зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд гарах үр дагавар, хариуцлагыг ИНЕГ хариуцахгүй.

**ДӨРӨВ. Нислэгийн хүсэлт гаргахад тавигдах шаардлага**

4.1.1 Нислэгийн хүсэлт гаргагч нь олон улсын болон орон нутгийн хөөрөлт, буултын хуваарьт нислэгийн хүсэлтийг журмын дагуу НУТБ болон ИНЕГ-ын Цагийн хуваарийн зөвлөл (цаашид “ЦХЗ” гэх)-д ирүүлнэ.

4.1.2 Нислэгийн хүсэлт гаргагч нь хуваарьт бус нислэгийн хүсэлтийг НУТБ-д ирүүлнэ.

4.1.3 Нислэгийн хүсэлтийг цахим хаяг, факс, цаасан хэлбэрээр ирүүлж болно.

4.1.4 “Урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээ”-нд орох нислэгийн мэдээллийг тухайн нислэг үйлдэхийн өмнөх ажлын өдрийн 14:00 цагаас өмнө “Хавсралт 5”-д заасан маягтын дагуу ирүүлнэ.

4.2 Хуваарьт нислэгийн хүсэлт

4.2.1 Нислэгийн хүсэлт гаргагч нь Монгол Улсын агаарын зайд үйлдэх олон улсын болон орон нутгийн хуваарьт нислэгийн хүсэлтийг тухайн нислэг эхлэхээс хуанлийн 30-аас багагүй хоногийн өмнө ирүүлнэ.

4.2.2 Нислэгийн хүсэлт гаргагч нь олон улсын хуваарьт нислэгийн хүсэлтийг журмын “Хавсралт 1”, орон нутгийн хуваарьт нислэгийн хүсэлтийг Хавсралт 3-т заасан маягтын дагуу тус тус ирүүлнэ.

4.3 Олон улсын хуваарьт бус нислэгийн хүсэлт

4.3.1 Нислэгийн хүсэлт гаргагч нь гадаад улсын онцгой үүргийн, тусгай үүргийн болон албан захиалгат нислэгийн хүсэлтийг нислэг эхлэхээс хуанлийн 2-оос багагүй хоногийн өмнө “Хавсралт 2”-т заасан маягтын дагуу ирүүлнэ.

4.3.2 Нислэгийн хүсэлт гаргагч нь олон улсын өнгөрөлтийн болон хөөрөлт, буултын нислэгийн хүсэлтийг нислэг эхлэхээс ажлын 2-оос багагүй хоногийн өмнө “Хавсралт 2”-т заасан маягт болон түүнд багтсан мэдээллийн дагуу ирүүлнэ.

4.3.3 Журмын 4.3.1, 4.3.2-т заасан хугацаанаас богино буюу нислэг эхлэхээс хуанлийн 1 хоногийн өмнө нислэгийн хүсэлтийг ирүүлсэн тохиолдолд агаарын

навигацийн хураамжийн төлбөрийг нэмэгдэл төлбөртэй тооцож, нислэгийн зөвшөөрлийг олгоно.

4.3.4 Журмын 4.3.3-т заасан хугацаанаас богино буюу нислэг эхлэхээс 6-аас багагүй цагийн өмнө нислэгийн хүсэлтийг ирүүлсэн тохиолдолд агаарын навигацийн хураамжийн төлбөрийг нэмэгдлийн нэмэгдэл төлбөртэй тооцож, нислэгийн зөвшөөрлийг олгоно.

4.3.5 Нислэгийн хүсэлт гаргагч нь тусгай үүргийн, хүмүүнлэгийн, түргэн тусламжийн, агаарын хөлөгт дутагдал гарч нислэг үйлдэх боломжгүй болсон үед өөр агаарын хөлгөөр нислэг үйлдэх, зорчигчдыг тээвэрлэх, сэлбэг хүргэх, навигацийн тоног төхөөрөмж болон техникийн шалгах нислэгийн хүсэлтийг "Хавсралт 2"-т заасан маягтын дагуу өнгөрөлтийн нислэг эхлэхээс 30 минутын өмнө, хөөрөлт буултын нислэг эхлэхээс 1 цагийн өмнө тус тус ирүүлнэ.

4.4 Орон нутгийн хуваарьт бус нислэгийн хүсэлт

4.4.1 Нислэгийн хүсэлт гаргагч нь иргэний агаарын хөлгөөр онцгой үүргийн нислэг үйлдэх нислэгийн хүсэлтийг хуанлийн 1-ээс багагүй хоногийн өмнө "Хавсралт 4"-т заасан маягтын дагуу ирүүлнэ.

4.4.2 Нислэгийн хүсэлт гаргагч нь улсын агаарын хөлгөөр онцгой үүргийн нислэг үйлдэх бол журмын 3.1.2-т заасан холбогдох хууль тогтоомжийг баримтална.

4.4.3 Нислэгийн хүсэлт гаргагч нь тусгай үүргийн, хүмүүнлэгийн, түргэн тусламжийн, агаарын хөлөгт дутагдал гарч нислэг үйлдэх боломжгүй болсон үед өөр агаарын хөлгөөр нислэг үйлдэх, зорчигчдыг тээвэрлэх, сэлбэг хүргэх, навигацийн тоног төхөөрөмж болон техникийн шалгах нислэгийн хүсэлтийг "Хавсралт 4"-т заасан маягтын дагуу нислэг эхлэхээс 30 минутын өмнө ирүүлнэ.

4.4.4 Нислэгийн хүсэлт гаргагч нь хуваарьт бус нислэгийн хүсэлтийг "Хавсралт 4"-т заасан маягтын дагуу нислэг эхлэхээс 2-оос багагүй цагийн өмнө ирүүлнэ.

**ТАВ. Нислэгийн өөрчлөлтөд тавигдах шаардлага**

5.1.1 Олон улсын болон орон нутгийн батлагдсан хуваарьт хөөрөлт, буултын нислэгийн цагийн хуваарьт 5 буюу түүнээс дээш тогтмол шинжтэй өөрчлөлт оруулах буюу нэмэгдэл нислэгийн хүсэлтийг Цагийн хуваарийн зөвлөлд хүргүүлнэ.

5.2 Өнгөрөлтийн нислэгийн өөрчлөлт

5.2.1 Нислэгийн хүсэлт гаргагч нь хуваарьт нислэгийн төлөвлөлтөд 1-4 удаагийн нислэг нэмэх тохиолдолд нислэгийн хүсэлтийг хуанлийн 1-ээс багагүй хоногийн өмнө "Хавсралт 1"-т заасан маягт эсхүл түүнд багтсан мэдээллийн дагуу ирүүлнэ.

5.2.2 Нислэгийн хүсэлт гаргагч нь хуваарьт нислэгийн төлөвлөлтөд 5 буюу түүнээс дээш өөрчлөлт болон нэмэгдэл нислэгийн хүсэлтийг нислэг эхлэхээс хуанлийн 5-аас багагүй хоногийн өмнө "Хавсралт 1"-т заасан маягт эсхүл түүнд багтсан мэдээллийн дагуу ирүүлнэ.

5.2.3 Нислэгийн хүсэлт гаргагч нь нислэгийн төлөвлөлтөд 1 удаагийн өөрчлөлт оруулах болон цуцалсан нислэгийн мэдээллийг тухай бүр ирүүлнэ.

5.3 Хөөрөлт, буултын нислэгийн өөрчлөлт

5.3.1 Нислэгийн хүсэлт гаргагч нь нислэгийн төлөвлөлтөд 1 удаагийн өөрчлөлт оруулах тохиолдолд нислэгийн хүсэлтийг холбогдох тайлбарын хамт нислэг эхлэхээс 1 цагаас багагүй хугацаанд ирүүлнэ.

5.3.2 Нислэгийн хүсэлт гаргагч нь батлагдсан хуваарьт нислэгийн төлөвлөлтөд 2-4 удаагийн өөрчлөлт оруулах болон нэмэгдэл нислэгийн хүсэлтийг нислэг эхлэхээс хуанлийн 3-аас багагүй хоногийн өмнө "Хавсралт 1"-т заасан маягтын дагуу ирүүлнэ.

## ЗУРГАА. Нислэгийн зөвшөөрөл

6.1 Нислэгийн зөвшөөрлийг цахим шуудангаар хүргүүлнэ.

6.2 Хуваарьт болон хуваарьт бус нислэгийн зөвшөөрөл нь хоорондоо ялгагдах үсгэн тэмдэглэгээ болон тоон дугаартай байна.

6.3 Хуваарьт нислэгийн зөвшөөрөл нь дараах үсгэн тэмдэглэгээ болон тоон дугаараас бүрдэнэ. Үүнд:

6.3.1 Олон улсын нислэгт:

6.3.1.1 Зуны улирлын: CAM зөвшөөрлийн дугаар/ нислэг үйлдэх он 'S
Жишээ нь: CAM 001/2023'S

6.3.1.2 Өвлийн улирлын: CAM зөвшөөрлийн дугаар/ нислэг үйлдэх он 'W
Жишээ нь: CAM 001/2023'W

6.3.2 Орон нутгийн нислэгт:

6.3.2.1 Зуны улирлын: CAM зөвшөөрлийн дугаар/ нислэг үйлдэх он 'S.D
Жишээ нь: CAM 001/2023'S.D

6.3.2.2 Өвлийн улирлын: CAM зөвшөөрлийн дугаар/нислэг үйлдэх он 'W.D
Жишээ нь: CAM 001/2023'W.D

6.4 Хуваарьт бус нислэгийн зөвшөөрөл нь дараах үсгэн тэмдэглэгээ болон тоон дугаараас бүрдэнэ. Үүнд:

6.4.1 Олон улсын нислэгт: CAM нислэг үйлдэх сар/зөвшөөрлийн дугаар-нислэг үйлдэх он
Жишээ нь: CAM 01/001-23

6.4.2 Орон нутгийн нислэгт: CAM нислэг үйлдэх сар/зөвшөөрлийн дугаар-нислэг үйлдэх он 'D
Жишээ нь: CAM 01/001-23'D

## ДОЛОО. Нислэгийн зөвшөөрлийн хүчинтэй хугацаа болон цуцлалт

7.1 Олон улсын нислэгт олгогдсон зөвшөөрөл нислэг эхлэх цагаас хойш 72 цагийн хугацаанд хүчинтэй байна.

7.2 Орон нутгийн нислэгт олгогдсон зөвшөөрөл нислэг эхлэх цагаас хойш 48 цагийн хугацаанд хүчинтэй байна.

7.3 Дотоодын Онцгой үүргийн болон Тусгай үүргийн нислэгт олгогдсон зөвшөөрөл нислэг эхлэх цагаас хойш 24 цагийн хугацаанд хүчинтэй байна.

7.4 Өнгөрөлтийн нислэгт онцгой тохиолдлын буулт үйлдсэн тохиолдолд олгогдсон нислэгийн зөвшөөрөл хүчинтэй байна.

7.5 Нислэгийн зөвшөөрлийн хүчинтэй хугацаа хэтэрсэн тохиолдолд зөвшөөрлийг шинээр авах тухай хүсэлтийг дахин гаргана.

7.6 ИНЕГ-ын холбогдох албан бичгийг үндэслэн нислэгийн зөвшөөрлийг цуцалж болно.

7.7 Агаарын навигацийн хураамжийн авлага хуримтлагдсанаас шалтгаалан Санхүү, эдийн засгийн нэгжээс албан мэдэгдэл ирүүлсэн тохиолдолд нислэгийн зөвшөөрлийг түр түдгэлзүүлэх болон цуцлах, улмаар авлагыг барагдуулснаар нислэгийн зөвшөөрлийг сэргээх зэргээр нислэгийн зөвшөөрөлд зохих хязгаарлалт хийж болно.

**НАЙМ. Баримт бичигт тавигдах шаардлага**

8.1 Хуваарьт нислэг

8.1.1 Нислэгийн хүсэлт гаргагч нь өнгөрөлтийн нислэг шинээр үйлдэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

8.1.1.1 Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ;

8.1.1.2 Агаарын хөлгийн улсын бүртгэлийн гэрчилгээ ("А" маягтад заасан бүх агаарын хөлгийн);

8.1.1.3 Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ ("А" маягтад заасан бүх агаарын хөлгийн);

8.1.1.4 Агаарын хөлгийн дуу чимээний гэрчилгээ /Шаардлагатай тохиолдолд нэмэлтээр авна/;

8.1.1.5 Даатгалын мэдээлэл;

8.1.1.6 Агаарын тээвэрлэгчийн албан ёсны хаяг.

8.1.2 Нислэгийн хүсэлт гаргагч (гадаад улсын) нь олон улсын хөөрөлт, буултын нислэг шинээр үйлдэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

8.1.2.1 Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ;

8.1.2.2 ИНД-129 “Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт” дүрмийн дагуу гэрчилгээжсэн гэрчилгээ;

8.1.2.3 Агаарын хөлгийн улсын бүртгэлийн гэрчилгээ ("А" маягтад заасан бүх агаарын хөлгийн);

8.1.2.4 Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ ("А" маягтад заасан бүх агаарын хөлгийн);

8.1.2.5 Агаарын хөлгийн дуу чимээний гэрчилгээ;

8.1.2.6 Даатгалын мэдээлэл;

8.1.2.7 Газрын үйлчилгээний мэдээлэл;

8.1.2.8 Нисэх буудалтай хийсэн үйлчилгээ үзүүлэх гэрээний мэдээлэл;

8.1.2.9 Агаарын тээвэрлэгчийн албан ёсны хаяг;

8.1.2.10Монгол Улс дахь салбар, нэгжийн хаяг эсхүл Монгол Улс дахь томилогдсон төлөөлөгч (ажилтан)-ийн холбоо барих хаягууд (утас, факс, и-мэйл г.м).

8.1.3 Нислэгийн хүсэлт гаргагч (дотоодын) нь шинээр нислэг үйлдэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

8.1.3.1 Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ;

8.1.3.2 Агаарын хөлгийн улсын бүртгэлийн гэрчилгээ;

8.1.3.3 Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ;

8.1.3.4 Даатгалын мэдээлэл;

8.1.3.5 Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын томилгооны бичиг.

8.1.3.6 Агаарын тээвэрлэгчийн албан ёсны хаяг.

8.2 Хуваарьт бус нислэг

8.2.1 Нислэгийн хүсэлт гаргагч нь олон улсын хөөрөлт, буултын нислэг үйлдэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

8.2.1.1 Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ (Арилжааны бус нислэг үйлддэг хувийн эзэмшлийн агаарын хөлөгт агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ шаардахгүй байж болно);

8.2.1.2 Агаарын хөлгийн улсын бүртгэлийн гэрчилгээ;

8.2.1.3 Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ;

8.2.1.4 Даатгалын мэдээлэл;

8.2.1.5 Газрын үйлчилгээний мэдээлэл;

8.2.1.6 Аюултай ачааны мэдээлэл.

8.2.2 Дотоодын агаарын тээвэрлэгчид 8.2.1 дэх заалтын зөвхөн 8.2.1.6 дахь дэд заалт хамаарна.

8.2.3 Нислэгийн хүсэлт гаргагч нь орон нутагт нислэг үйлдэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

8.2.3.1 Хилийн бүсэд нислэг үйлдэх бол улсын хил хамгаалах байгууллагаас олгосон зөвшөөрөл;

8.2.4 Нислэгийн хүсэлт гаргагч (дотоодын) нь орон нутагт шинээр нислэг үйлдэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

8.2.4.1 Агаарын тээврийн гэрчилгээ (Арилжааны бус нислэг үйлддэг хувийн эзэмшлийн агаарын хөлөгт агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ шаардахгүй байж болно);

8.2.4.2 Агаарын хөлгийн улсын бүртгэлийн гэрчилгээ;

8.2.4.3 Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ;

8.2.4.4 Даатгалын мэдээлэл.

8.2.5 Нислэгийн хүсэлт гаргагч (гадаад улсын болон гадаад улсад бүртгэлтэй агаарын хөлөг) нь орон нутагт нислэг үйлдэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

8.2.5.1 Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ (Арилжааны бус нислэг үйлддэг хувийн эзэмшлийн агаарын хөлөгт агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ шаардахгүй байж болно);

8.2.5.2 Агаарын хөлгийн улсын бүртгэлийн гэрчилгээ;

8.2.5.3 Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ;

8.2.5.4 Даатгалын мэдээлэл;

8.2.5.5 Засгийн газар хоорондын агаарын харилцааны хэлэлцээр болон Монгол Улсын төрийн захиргааны төв байгууллагын захиалгаар гүйцэтгэх ажлын төрөл, захиалагчтай байгуулсан гэрээ;

8.2.5.6 Нислэг үйлдэх чиглэл, маршрут, ажлын талбайн бүдүүвч, байрлах газрын солбицол.

## ЕС. Ерөнхий зориулалтын нисэх

9.1 Нислэгийн хүсэлт гаргагч нь хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэх тохиолдолд нислэгийн төлөвлөгөө (FPL)-г Иргэний нисэхийн дүрмийн дагуу зөвхөн Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагад хүргүүлэх бөгөөд ИНЕГ-аас нислэгийн зөвшөөрөл олгохгүй.

9.2 Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагааны нислэгийн аюулгүй байдлыг агаарын хөлгийн дарга болон эзэмшигч бүрэн хариуцна.

9.3 Хяналтгүй агаарын зайнаас хяналттай агаарын зайд, эсхүл хяналттай агаарын зайнаас хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэх бол нислэгийн хүсэлтийг энэ журмын дагуу ирүүлнэ.

## АРАВ. Харилцагч байгууллагын хамтын ажиллагаа

10.1 Цагийн хуваарийн зөвлөл

10.1.1 ИНЕГ, ИНҮТ болон нисэх буудлын төлөөллөөс бүрдсэн Цагийн хуваарийн зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) ажиллана.

10.1.2 Олон улсын болон орон нутгийн нисэх буудлуудын багтаамж, үйлдвэрлэл, үйлчилгээний нэвтрэн өнгөрүүлэх хүчин чадал, агаарын тээвэрлэгчдийн тээвэрлэлтийн боломжтой уялдуулан хуваарьт нислэгийн цагийн хуваарийг нэгтгэх, батлах, хэрэгжүүлэх, нэмэлт өөрчлөлт оруулахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулна.

10.1.3 Олон улс, орон нутгийн нисэх буудалд хуваарьт нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчийн батлагдсан нислэгийн цагийн хуваарийг НУТБ-д ирүүлнэ.

10.1.4 Хуваарьт нислэгийн батлагдсан цагийн хуваарьт өөрчлөлт орсон тохиолдолд шинэчилсэн хуваарийг НУТБ-д ирүүлнэ.

10.2 Иргэний нисэхийн ерөнхий газар

10.2.1 Иргэний нисэхийн ерөнхий газар нь Иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн агаарын тээвэрлэгч, нисэх буудал, агаарын хөлгийн бүртгэл, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээний талаарх мэдээллийг тухай бүр www.mcaa.gov.mn сайтад байршуулна.

10.2.2 Тусгай нислэгийн зөвшөөрлийг олгох тохиолдолд НУТБ-д албан бичгээр эсхүл цахим хаягаар ирүүлнэ.

10.2.3 Агаарын тээвэрлэгчээс ирүүлсэн аюултай ачааны мэдээлэлтэй танилцан, саналыг НУТБ-д ирүүлнэ.

10.2.4 Нислэгийг зогсоох, цуцалсан талаарх мэдээллийг албан бичгээр эсхүл цахим хаягаар НУТБ-д ирүүлнэ.

10.3 “ИНҮТ” ТӨХХК-ийн Санхүү, эдийн засгийн нэгж

10.3.1 Нислэгийн гүйцэтгэлийн тайланг сард 2 удаа НУТБ–аас хүлээн авна.

10.3.2 Нислэгийн хүсэлт гаргагчаас ирүүлсэн хуваарьт, хуваарьт бус нислэгийн хүсэлтийн хувийг НУТБ-аас хүлээн авна.

10.3.3 Санхүү, эдийн засгийн нэгжээс журмын 7.7-д заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай санал, мэдэгдлээ НУТБ-д албан бичгээр ирүүлнэ.

10.4 Нисэх буудлууд

10.4.1 Нисэх буудлууд нь урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээг https://atfm.ncac.mn цахим хуудсаар хүлээн авна.

10.4.2 Нисэх буудлуудын ачаалалтай болон сул цагийн талаарх мэдээллийг НУТБ-д тогтмол хүргүүлнэ.

**АРВАН НЭГ. Нислэгийн төлөвлөлтийн мэдээний хадгалалт**

11.1 Олон улс, орон нутгийн нислэгийн зөвшөөрлийн бүртгэл болон нислэгийн гүйцэтгэлийн тайланг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу “ИНҮТ” ТӨХХК-ийн архивт шилжүүлнэ.

**АРВАН ХОЁР. Хавсралт**

ХАВСРАЛТ 1.

**FORM "A".**

| A.<br>OPERATOR | B.<br>ADDRESS |
|---|---|
| | |

| № | C.<br>Flight number | D.<br>Main and alternative route | E.<br>ACFT type | F.<br>ACFT EQPT ACAS/TCAS YES/NO | G.<br>Days of operation | H.<br>Point of departure/ ETD | I.<br>Entry point Time | J.<br>Exit point time | K.<br>Point of destination/ ETA | L.<br>Via airways | M.<br>Period of flight | N.<br>Remarks |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| 2 | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| 4 | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |

| | | | |
|---|---|---|---|
| 1 | MAXIMUM ALL-UP WEIGHT | | |
| 2 | TYPE AND REGISTRATION MARKS OF AIRCRAFT | | |
| 3 | PURPOSE OF FLIGHT | | |
| 4 | CRUISING SPEED | | |
| 5 | RVSM APPROVAL YES/NO | | |
| 6 | ALL TYPES OF RNP/RNAV | | |
| 7 | ACFT EQPT GPWS YES/NO | | |

/All times in UTC/

ХАВСРАЛТ 2.

**FORM "B".**

**APPLICATION**
**FOR NON-SCHEDULED FLIGHT REQUEST**

This form, duly completed, must be sent to the Civil Aviation Authority of Mongolia no later than 2 working days before the flight for both landing and overflight.

*Note: Domestic airports cannot be used as alternate airports for international flights.*

| | | |
|---|---|---|
| 1 | NAME OF AIRLINE | |
| 2 | OPERATOR | |
| 3 | BILLING ADDRESS<br>(POC, TEL, FAX, E-MAIL, BOX) | |
| 4 | NATIONALITY OF ACFT | |
| 5 | CALLSIGN | |
| 6 | REGISTRATION OF ACFT | |
| 7 | TYPE OF ACFT | |
| 8 | MTOW / LANDING WEIGHT | |
| 9 | PURPOSE OF FLIGHT | |
| 10 | CATEGORY OF FLIGHT<br>(CHARTER, ADDITIONAL, VIP AND OTHER) | |
| 11 | DATE OF FLIGHT | |
| 12 | DEPARTURE AERODROME / ETD | |
| 13 | DESTINATION AERODROME / ETA | |
| 14 | ENTRY POINT / ETO | |
| 15 | EXIT POINT / ETO | |
| 16 | FLIGHT ROUTE | |
| 17 | ACFT EQPT (ACASII/TCAS) YES/NO | |
| 18 | ACFT EQPT GPWS | |
| 19 | RVSM YES/NO | |
| 20 | ALL TYPES OF RNP/RNAV | |
| 21 | FLIGHT CREW | |
| 22 | PASSENGERS | |
| 23 | THE FORM OF PAYMENT/<br>(Contact information for billing) | |
| 24 | DANGEROUS GOODS | |
| 25 | REMARKS | |

/All times in UTC/

ХАВСРАЛТ 3.

**FORM “C”.**

Агаарын тээвэрлэгчийн хаяг

АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧИЙН НЭР

20.. оны ... -р сарын ... -ны өдөр Дугаар ... Улаанбаатар хот

БАТЛАВ. ЗАХИРАЛ ..... / /

**20 . . ОНЫ ... -Р САРЫН ... -ЭЭС ... –Р САРЫН ... -НЫ ӨДРИЙГ ДУУСТАЛХ ХУГАЦААНД ҮЙЛДЭХ ХУВААРЬТ НИСЛЭГИЙН ХҮСЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ /ДООГУУР ЗУРАХ/**

| № | Аяллын дугаар | А/х-ийн маяг | Хөөрөх буудал | Буух буудал | Нисэн гарах цаг | Нисэн очих цаг | Нислэг хийх өдрүүд | Нислэг эхлэх өдөр | Нислэг дуусах өдөр | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |

/Улаанбаатарын цагаар/

ХАВСРАЛТ 4.

**FORM “D”.**

Агаарын тээвэрлэгчийн хаяг

АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧИЙН НЭР

20.. оны ... -р сарын ... -ны өдөр Дугаар ... Улаанбаатар хот

БАТЛАВ. ЗАХИРАЛ ..... / /

**20 . . ОНЫ ... -Р САРЫН ... -НЫ ӨДРИЙН ХУВААРЬТ БУС НИСЛЭГИЙН ХҮСЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ /ДООГУУР ЗУРАХ/**

| Агаарын хөлгийн маяг | Агаарын хөлгийн бүртгэлийн дугаар | Агаарын хөлгийн дарга | Агаарын хөлгийн даргын минимум | Нислэгийн зорилго |
|---|---|---|---|---|
| | | | | |

| № | Аяллын дугаар | Огноо | Нислэгийн чиглэл | Агаарын замын дугаар | Хөөрөх цаг | Буух цаг | Координат | Тайлбар | Чиглэлийн зай |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |

/Улаанбаатарын цагаар/

Тусгай хамгаалалттай газар нутагт нислэг үйлдэх эсэх: ☐ Тийм ☐ Үгүй

Нислэг үйлдэх агаарын зайн хязгаарлалт, аэродромын өгөгдөл, мэдээлэлтэй танилцсан эсэх: ☐Тийм ☐Үгүй

ХАВСРАЛТ 5.

**FORM “E”.**

АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧИЙН НЭР

20.. оны ... -р сарын ... -ны өдөр
Улаанбаатар хот

**20 . . ОНЫ ... -Р САРЫН ... -НЫ ӨДРИЙН ХУВААРЬТ, ХУВААРЬТ БУС НИСЛЭГИЙН МЭДЭЭЛЭЛ**

| № | Аяллын дугаар | Огноо | Агаарын хөлгийн маяг | Агаарын хөлгийн бүртгэлийн дугаар | Нислэгийн төрөл | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |
| | | | | | | |

/Улаанбаатарын цагаар/